



## Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо

# "БИ СЭЛЖ СУРЛАА" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

2024 ОНЫ 09 САРЫН 05-НЫ ӨДӨР  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР БАТЛАВ



## Нэг. НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1 2014 оны Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)-ын судалгаагаар жилд 372.000 хүн буюу Минут тутамд 1 хүн усанд живж энддэг бол Монгол улсад жилд дунджаар 80 орчим хүн усанд осолддог гэсэн мэдээ байдаг.
- 1.2 Сэлж сурах нь бүх насны хүмүүст шаардлагатай дасгал хөдөлгөөний хэрэгцээг хангахаас гадна, олон зуун амь насыг усанд живэх болон байгалийн гамшигт үзэгдлийн үед өөрсдийгөө авран хамгаалах боломжийг нь нэмэгдүүлнэ.
- 1.3 Монгол улсад усан спортын бүх төрлийг хөгжүүлэхэд олон улсын стандарт, шаардлагыг хангасан бассейныг бүтээн байгуулах ажил зайлшгүй бөгөөд энэхүү ажилд олон нийт болон төрийн байгуулагуудын анхаарлыг хандуулах шаардлагатай байна.
- 1.4 Сэлж сурах нь хүний амьдралыг чанарыг сайжруулж, амралт чөлөөт цагаа эрсдэлгүй, тааламжтай өангөрүүлэх боломжийг олгоно.

## Хоёр. ЗОРИЛГО

- 2.1 Усанд сэлэлтийн спортыг олон нийтэд хүртээмжтэй, хүүхэд залуучуудын хичээллэх дуртай спортын төрөл болгон хөгжүүлэх.
- 2.2 Авьяаслаг, ирээдүйтэй тамирчдыг нээн илрүүлж, усны спортоор хичээллэх боломжийг олгох.
- 2.3 Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны "Swimming for all-Swimming for life" хөтөлбөрийг дэмжих.
- 2.4 Бүх насны бүлгийн хүмүүсийг өргөн цар хүрээтэйгээр усанд сэлж сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах.
- 2.5 Усан спортоор хичээллэснээр амьдралын чанарт үзүүлэх эерэг нөлөө болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд усыг хэрхэн ашиглаж үр дүнд хүрч байгаа талаархи үнэн бодит мэдээллийг олон нийтэд түгээх.
- 2.6 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээг ашиглан усны бүх төрлийн спортын талаар мэдлэг мэдээлэл олгох, сурталчлан таниулах ажлыг үе шаттай зохион байгуулах.
- 2.7 Ахмад настнууд сонирхол нэгт хүмүүстэйгээ уулзаж нөхөрлөх, цагийг зорилго тэмүүлэлтэй өнгөрүүлэх шинэ орон зайг бий болгох



### Гурав. ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧИД БОЛОН ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

- 3.1 МУССХ-ны Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага хөтөлбөрийг ерөнхий удирдлагаар хангана.
- 3.2 Хөтөлбөрийг МУССХ-ны нийт гишүүн клуб, байгууллагууд хэрэгжүүлэх бөгөөд Удирдах зөвлөлийн дэргэдэх мэрэгжлийн зөвлөлүүд дэмжин оролцоно.
- 3.3 Хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ жил бүрийн 09 сарын 15-аас 10 сарын 15-ны хооронд
- 3.4 Хөтөлбөрийн тайлангийн арга хэмжээ буюу "Би сэлж сурлаа" нөхөрсөг тэмцээн дараа оны 05 сарын 01-нээс 06 сарын 01-ний хооронд зохион байгуулагдана.

### Дөрөв. ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД

- 4.1 Хөтөлбөрийн талаархи мэдээлэл болон усанд сэлж сурах, усан спортын төрлүүдээр хичээллэхийн ач тусыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх
- 4.2 Хөтөлбөрт хамрагдаж байгаа бассейн сургалтын төвүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг /сургалтын хөтөлбөр, байрлал, төлбөр г.м / хүргэх
- 4.3 "Би сэлж сурлаа" хөтөлбөрийн хүрээнд ашиглагдах дурсгалын медалийг захиалан бэлтгэж гишүүн клуб, байгууллагуудад түгээх
- 4.4 Баригдаж дууссан болон дуусах шатандаа байгаа бассейнуудыг ашиглалтанд оруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
- 4.5 Усанд сэлж сурахын ач тус болон усанд живэх эрсдлээс сэргийлэх талаар контент бэлтгэх
- 4.6 Усанд осолдогчдод үзүүлэх анхны тусламжийн талаархи сургалтыг багш дасгалжуулагчдын дунд тогтмол зохион явуулж хэвшүүлэх, үе шаттай сертефикаттай болгох( цаашлаад ард иргэдэд зааж сургах)
- 4.7 Хөтөлбөр хэрэгжих хугаацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг усаар эрүүлжүүлэх ажил зохион явуулах, цаашлаад паралимпийн тамирчид бэлтгэх
- 4.8 Хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн үед бүртгэгдсэн шинэлэг санал санаачлагыг дараа жилийн хөтөлбөрт тусгах, олон нийтэд сурталчлан мэдүүлэх
- 4.9 Хөтөлбөрийн үр дүнгээр амжилт гаргасан Холбооны гишүүн клуб, байгууллага, хувь хүнийг урамшуулах
- 4.10 Биеийн тамирын дээд сургууль, спортын гүнзгийрүүлсэн сургалттай дунд сургууль болон Ерөнхий боловсролын дунд сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт усанд сэлэлтийг багтаах талаар үе шаттай ажил зохион байгуулах



## Тав. ГИШҮҮН КЛУБ, БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУД

- 5.1 Усанд сэлж сургах сургалтын үйл ажиллагаагаа үе шаттай өргөжүүлэх
- 5.2 Хөтөлбөрийн хүрээнд мөрдөгдөх хөнгөлөлттэй төлбөрийн саналыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бий болгож мөрдүүлэхийг зорих
- 5.3 Сургалтын үйл ажиллагааг удирдан явуулах багш, дасгалжуулагчдынхаа тоо болон ур чадварыг нэмэгдүүлэх
- 5.4 Байгууллага, клубынхаа сургалтын үйл ажиллагаа болон усанд сэлж сурахын ач холбогдлын талаархи контент бэлтгэн сурталчлах
- 5.5 "Би сэлж сурлаа" хөтөлбөрийг өөрсдийн хөтөлдөг нийгмийн сүлжээний платформыг ашиглан сурталчлах

## Зургаа. ДҮГНЭХ

- 6.1 Гишүүн байгууллага, клуб, хувь хүмүүс нь хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын үр дүн, тайланг маягтын дагуу холбооны гүйцэтгэх удирдлагад тогтоосон хугацаанд ирүүлнэ. Дэмжих баримтуудыг хавсарган ирүүлэх боломжтой.
- 6.2 Холбооны гүйцэтгэх удирдлага болон Удирдах зөвлөлүүдийн дэргэдэх зөвлөлүүдийн дэмжсэн тайланг Удирдах зөвлөлд танилцуулж шилдгүүдийг тодруулах бөгөөд "Оны тамирчин шалгаруулах ёслолын арга хэмжээ"-ний үеэр шагнаж, алдаршуулах ажлыг зохион байгуулна.
- 6.3 Хөтөлбөрийн үр дүнг дүгнэхэд ашиглах асуумж, маягт болон тусгайлсан журмыг Удирдах зөвлөл батлан гаргаж болно.